

Японы “Жайка” байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл”

Утааны хийн хэмжилтийн ажлын тайлан

(2011 оны 10 сар- 2011 оны 3 сар)

2010 оны 10 сараас эхлэн 2011 оны 3 дугаар сар хүртэлхи хугацаанд УХЗ-ны байгууламжийн 21 зууханд утааны хийн хэмжилтийг хийсэн өгөөд тус хэмжилтэнд төслийн хүрээнд нийлүүлэгдсэн хаягдал утааны хийн хэмжилтийн багаж тоног төхөөрөмжийг ашиглан хийж гүйцэтгэсэн юм.

Тус хэмжилтээр тухайн цэгэн эхүүсвэрээс агаарт хаягдаж буй СО- угаарын хий, NOx-азотын ислүүд, SO₂-хүхэрлэг хий болон үнс тоосны агууламжийг хэмжиж гаргасан болно.

2010 оны зун хаягдал утааны хийн хэмжилтийн сургалтыг Япон улсад зохион байгуулсан өгөөд тус сургалтанд оролцсон хамтрагч талууд болон НАЧА-ны холбогдох мэргэжилтнүүд хэмжилт хийж мэргэжлийн ур чадавхиа дээшүүлж, дадлага туршлагаас нь суралцсан. Мөн төслийн япон мэргэжилтнүүд хэмжилтийг хамт хийлцэж, харилцан мэдлэг туршлагаасаа хуваалцаж байлаа.


Хамтрагч талууд Монгол талаас:


Нэр	Байгууллагын нэр
Г.Даваажаргал	НАЧА
М.Отгонбаяр	НАЧА
Э.Эрдэнэбаатар	НАЧА
Алтангэрэл	ДЦС-4
Мөнхтулга	ДЦС-4
Энхтүвшин	ДЦС-2

Төслийн талаас:

Нэр	Байгууллагын нэр
Сакурай	ЖАЙКА төслийн мэргэжилтэн
Тадаёши Үсүй	ЖАЙКА төслийн мэргэжилтэн
Тошихару Очи	ЖАЙКА төслийн мэргэжилтэн
Нобухиро Хонда	ЖАЙКА төслийн мэргэжилтэн

Тухайн жилийн хэмжилтийнүдг MNS 5457 -2005 “Халаалтын болон гэрийн зуухны яндангаар гарах угааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын хүлцэх дээд хэмжээ ба хэмжих арга” стандарттай харьцуулан гаргасан болно. Хэмжилтийн дүнг графикаар үзүүлбэл:





Тайлбар: Эдгээр хэмжилтүүдийг 2010 онд хийсэн бөгөөд төслийн хүрээнд нийлүүлэгдэх автомат багаж, тоног төхөөрөмж хараахан бүрэн ирээгүй байсан тул зарим хэмжилтүүдийг гар аргаар хийсэн болно. Тухайн хэмжилтүүдийг хийхдээ гар аргаар хийсэн хэмжилтийн үр дүнг 2 азар дээр нь боловсруулалт хийж дээжийг авч байсан тул хэмжилтийн зарим хэмжилтийн утга агууламжийн хувьд нарийвчлал багатай гарсан байх магадлалтай болно. Тухайн үед хэрэглэж байсан хаягдал утааны хийн анализатор Тесто-350 багаж удаан хугацааны туршид тасралтгүй хэмжилт хийх боломжгүй байсан тул хэмжилтийг тухайн зуухны ажиллаж байх үед нэгж хугацааны хэмжилтийг хийж байсан болно.

Мөн УХЗ-наас гадна Улаанбаатар хотод байгаа ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4-уудад нийт 13 удаа утааны хийн хэмжилт хийсэн болно.